

**“МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРГИЙН ЗҮЙЛЧЛЭЛ, ТУЛГАМДАЖ БУЙ
АСУУДАЛ, ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА” СЭДЭВТ ЭРДЭМ
ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН УДИРДАМЖ**

Сэдэв: “Мөнгө угаах гэмт хэргийн зүйлчлэл тулгамдаж буй асуудал, цаашдын чиг хандлага”

Зорилго: Мөнгө угаах гэмт хэргийн зүйлчлэл, тулгамдаж буй асуудал, цаашдын чиг хандлагыг тодорхойлж холбогдох хууль тогтоомж, түүний шинэчлэлт, хэрэгжилт, мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх, мөрдөн шалгах ажиллагаанд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга замын талаарх онол, практикийн асуудлыг эрдэмтэн, судлаач, практик байгууллагын ажилтнуудын хүрээнд хэлэлцүүлж, тэдний эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүн, санал, дүгнэлтийг судалгааны эргэлтэд оруулж, тэдгээрт үндэслэсэн зөвлөмж гаргахад оршино.

Зорилтууд:

1. Монгол Улсын Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх ажилд дэмжлэг үзүүлэх, судалгааны ажлын зарим үр дүнг нээлттэй хэлэлцүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;
2. Мөнгө угаах гэмт хэргийн зүйлчлэл ба цаашдын чиг хандлагыг тодорхойлох түүнийг шийдвэрлэх арга замыг боловсронгуй болгох хүрээнд эрдэмтэд, судлаачид, профессор багш, мэргэжилтнүүдийн төрөлжсөн судалгааны үр дүнг нэгтгэх,
3. Монгол Улсын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх “Хамтын ажиллагааны зөвлөл”-ийн дэргэдэх “Хууль сахиулах ажлын хэсэг”, “Хууль эрх зүйн ажлын хэсэг”-ийн төлөвлөгөөний биелэлтийг хангах;

Зохион байгуулагчид:

Санаачлан зохион байгуулагч: Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн алба;

Хамтран зохион байгуулагч: Монголбанк, Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын ерөнхий прокурорын газар, Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар;

Эрдэм шинжилгээний хурлын сэдвийн хүрээнд:

1. Мөнгө угаах гэмт хэргийн хууль эрх зүйн орчин ба цаашдын чиг хандлага
2. Мөнгө угаах гэмт хэргийн зүйлчлэлд тулгамдаж буй асуудал
3. Мөнгө угаах гэмт хэргийг шалгаж шийдвэрлэхэд тулгарч буй хүндрэл бэрхшээл, шийдвэрлэх арга зам
4. Мөнгө угаах гэмт хэргийг шийдвэрлэж буй шүүхийн практик түүний зарим асуудал
5. Мөнгө угаах гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн ойлголт ба олон улсын жишиг
6. Мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргийн ойлголт, олон улсын жишиг
7. Мөнгө угаах гэмт хэргийн субъектийн онцлог (өөрөө болон гуравдагч этгээдээр үйлдлээр дамжуулан мөнгө угаах гэмт хэрэг үйлдэх)
8. Мөнгө угаах гэмт хэргийн талаар статистик мэдээлэл солилцооны өнөөгийн байдал, боловсронгуй болгох аргачлал, олон улсын стандарт шаардлага
9. Виртуал хөрөнгө ашиглан мөнгө угаасан гэмт хэргийн мөрдөн шалгах аргачлал түүнийг боловсронгуй болгох асуудал

10. Санхүүгийн мэдээллийн алба болон хууль сахиулах байгууллагууд мөнгө угаахтай тэмцэхэд хамтран ажиллах нь

11. Дээрхи сэдвүүдийн хүрээнд

Хамрах хүрээ:

- Шүүгч;
- Прокурор;
- Мөрдөгч;
- Өмгөөлөгч;
- Хуульч;
- Судлаач;
- Бусад (Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагын ажилтан, алба хаагч)

Явагдах газар: “Холидэй-Ин” зочид буудлын хурлын заал

Хугацаа: 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр, 10.00-17.00 цагт

Хүрэх үр дүн:

1. Мөнгө угаах гэмт хэргийн хууль эрх талаар прокурор, шүүгч, мөрдөгч, хуульч, өмгөөлөгч, судлаач, бусад (Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагын ажилтан, алба хаагч) этгээдүүд нэгдсэн ойлголтод хүрэх, зөвлөмж гаргах.

2. Эрдэм шинжилгээний бага хурлаас гарсан санал зөвлөмжийг онол, практикийн түвшинд ашиглах, эрдэм шинжилгээнд ашиглах, харилцан ажиллагаатай байгууллагуудын арга барил, туршлагыг нэвтрүүлэх.

3. Гадаад улс орнуудын тэргүүн туршлагаас суралцах.

Тавигдах шаардлага:

А. Илтгэлийн агуулгад:

- Илтгэлийг хэлэлцэх агуулгын хүрээнд бичсэн байх;
- Судалгааны ажил бодит баримт, тодорхой судалгаанд үндэслэсэн байх;
- Шинэлэг санаа, дүгнэлттэй байх;

Б. Илтгэлийн бүтцэд:

- Илтгэл нь товч агуулга, түлхүүр үг, үндсэн хэсэг, дүгнэлт, ном зүй зэргээс бүрдсэн байх;
- Эх сурвалж, ишлэл зүүлтийг тусгасан байх;
- Үзүүлэх материалуудыг хавсаргаж болно.

В. Илтгэлд тавигдах техник шаардлага:

- Microsoft Office Word, Arial, үсгийн хэмжээ 12, хуудасны зүүн талаас 3,0 см бусад талаас 2,0 см зайтай, А4 формат, мөр хоорондын зай 1,15 байна. Илтгэгч овог, нэр, албан тушаал, холбоо барих утас, цахим хаягаа бичнэ. Илтгэлийг хамтран бичиж оролцож болно.

- Хуудасны тоо 3-8 нүүр;
- Илтгэлийн эхийг цахим хэлбэрээр ppt болон Прези-ийн хамт хүлээн авна;
- Шалгарсан илтгэлүүдийг эмхтгэлд хэвлүүлнэ.

Цагийн зохион байгуулалт:

- Илтгэгчийн үндсэн илтгэлийн хугацаа: 15 минут;
- Асуулт хариулт: 5 минут байна.

Шалгаруулалт:

- Нэгдүгээр шат: Зохион байгуулах комисс бүтээлийг хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүлээн авч судалгааны ажлыг дүгнэх.

- Хоёрдугаар шат: ЭШХ-ын зохион байгуулж буй ажлын хэсгээс 10 илтгэлийг шалгаруулна.

- Гуравдугаар шат: Шалгарсан эрдэм шинжилгээний илтгэлийг 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр хэлэлцүүлнэ.

Хугацаа: 2022 оны 03 дугаар сарын 25-ны дотор шалгаруулж илтгэгч нарт мэдэгдэнэ.

Шагнал, урамшуулал:

- Ирүүлсэн илтгэл нь шалгарч хэлэлцүүлэгт оролцсон илтгэгчдэд үнэ бүхий зүйл, мөнгөн урамшуулал олгоно.

Материал хүлээн авах:

Хугацаа: 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 17:00 цаг хүртэл бүтээлийн хэвлэмэл 2 хувийг Эрүүгийн цагдаагийн албаны Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн мэргэжилтэн, цагдаагийн ахмад Ш.Жамъяндоржид /утас:96016789/ болон цахим хэлбэрээр Jamiyandorj.sh@police.gov.mn хаягаар хүлээн авна.

ЭРҮҮГИЙН ЦАГДААГИЙН АЛБА